



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хангал сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/03/НА-СА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 70342580 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn
Булган аймаг	Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn
2023 он	Аудитор: Г.Намчинсүрэн Утас: 70342716 Цахим хаяг: namchinsureng@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
3.4.1 Мөнгөн хөрөнгө	13
3.5.2 Авлага	14
3.5.3 Урьдчилгаа	14
3.5.4 Бараа материал	14
3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө	15
3.5.6 Үндсэн хөрөнгө	15
3.5.7 Өр төлбөр	16
3.5.10 Засгийн газрын хувь оролцоо	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	19
4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.7.1 Завсрын аудитын талаар.....	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
5.3 Зөвлөмж.....	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БЕГ	Боловсролын ерөнхий газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ЖДҮДС	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.03.25 № 333

танай _____ ны № _____ т

ХАНГАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА
М.ТӨМӨРБАТ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хангал сумын ТТЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хангал сумын ТТЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор санхүүгийн нэгдсэн тайлангаар авлага 21 хувь буюу 16,491.3 мянган төгрөгөөр барагдаж, өглөг 13,002.8 мянган төгрөг буюу 93.2 хувиар өссөн, батлагдсан төсвөөс зардлыг 332,867.27 мянган төгрөгөөр хэмнэж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудлыг тодорхойлоход материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн үнэлгээ өндөр, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын шийдвэр гаргасан чухал асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг

006020777

харгалзаж үзнэ.

Хангал сумын ТТЗ нь орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 3,821,184.3 мянган төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 3,696,524.8 мянган төгрөгөөр буюу 3.3 хувиар тасарсан байна.

Бусад асуудлын хэсэг

Хангал сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээгээр 2023 онд 148 ажил төлөвлөснөөс 139 ажлыг гүйцэтгэж гүйцэтгэлийн биелэлт 96.6 хувиар дүгнэгджээ.

АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүссэн тухай, санхүүгийн тайлангийн аудит, аудитын тайлантай холбоотой аудиторын хүлээх үүрэг хариуцлагын тухай дэлгэрэнгүй тайлбар өгөхөөр хууль тогтоомжоор шаардсан мэдээллийг тусгана.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.ЭРДЭНЭ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/			
Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	386,122.30	619,835.80
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	85,012.60	208,208.60
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0	0
33	АВЛАГА	77,328.40	60,837.10
34	УРЬДЧИЛГАА	0	0
35	БАРАА МАТЕРИАЛ	223,781.30	200,790.10
36	НӨӨЦИЙН БАРАА	0	0
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	0	150,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,364,673.30	2,167,590.60
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	248,610.50	200,322.40
37100	Урт хугацаат хадгаламж	0	0
37200	Үнэт цаас	0	0
37300	Урт хугацаат зээл	248,610.50	200,322.40
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,116,062.80	1,967,268.30
39100	Газар	0	0
39200	Биет хөрөнгө	1,110,509.40	1,121,732.90
39300	Биет бус хөрөнгө	5,553.40	845,535.40
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	0	0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,750,795.60	2,787,426.50
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,041.80	14,922.90
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,041.80	14,922.90
41100	Богино хугацаат үнэт цаас	0	0
41200	Богино хугацаат зээлийн өглөг	0	0
41300	Өглөг	3,041.80	14,922.90
41400	Урьдчилж орсон орлого	0	0
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	0
42100	Урт хугацаат үнэт цаас	0	0
42200	Урт хугацаат зээл	0	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,747,753.80	2,772,503.60
51	Засгийн газрын хувь оролцоо	1,747,753.80	2,772,503.60
51100	Засгийн газрын оруулсан капитал	249,447.10	249,447.10
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	0	0
51102	Өмч /хувийн/ /ТӨҮГ/	0	0
51103	Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	0	0
51104	Халаасны хувьцаа /ТӨҮГ/	0	0
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	0	0
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	0	0
51200	Хуримтлагдсан үр дүн	1,470,516.00	2,495,265.70
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	27,790.80	27,790.80
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0	0
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	0	0
51600	Нөөцийн сан	0	0
52	Хяналтын бус хувь оролцоо	0	0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,750,795.60	2,787,426.50

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,804,015.10	7,766,871.80
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,135,595.10	3,373,717.20
110	Орлогын албан татвар	102,248.60	165,231.80
1100	Хувь хүний орлогын албан татвар	102,248.60	165,231.80
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0	0
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	0	0
1103	ААН-ын орлогын албан татвар	0	0
1104	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	0	0
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	0	0
113	Хөрөнгийн албан татвар	902,208.60	3,060,252.50
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар	0	0
115	Онцгой албан татвар	0	0
116	Тусгай зориулалтын орлого	0	0
117	Гадаад үйл ажиллагааны орлого	0	0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	131,137.90	148,232.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	195,333.00	991,727.60
120	Нийтлэг татварын бус орлого	195,333.00	991,727.60
121	Хөрөнгийн орлого	0	0
122	Тусламжийн орлого	0	0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0	0
124	Зээлийн орлого	0	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,473,086.90	3,401,427.10
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,433,485.00	6,169,962.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,433,485.00	6,169,962.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	883,490.70	1,289,812.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	315,099.40	566,427.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,780.90	70,889.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	305,146.80	139,637.90
2104	Хангамж, бараа материалын зардал	31,926.00	32,981.00
2105	Нормативт зардал	468.8	1,430.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,078.90	54,077.80
2107	Томилолт, зочны зардал	7,078.00	23,479.70
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,072.10	42,976.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	169,839.80	357,911.70
211	ХҮҮ	0	0
212	ТАТААС	0	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,549,994.20	4,880,149.80
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	370,530.10	1,596,909.80
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	5,772.00	3,506.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,061,027.80	575,651.10
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,684,725.70	1,024,764.80

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мянган
төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,462,784.2	0.0	3,462,784.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-30,304.6	0.0	-30,304.6
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,432,479.6	0.0	3,432,479.6
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	-1,684,725.7	0.0	-1,684,725.7
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,747,753.8	0.0	1,747,753.8
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,747,753.8	0.0	1,747,753.8
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-15.0	0.0	-15.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,747,738.8	0.0	1,747,738.8
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	1,024,764.8	0.0	1,024,764.8
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	2,772,503.6	0.0	2,772,503.6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ мянган
төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,797,972.2	7,208,580.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,135,595.1	3,373,717.2
110	Орлогын албан татвар	102,248.6	165,231.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	102,248.6	165,231.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	0.0
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	0.0	0.0
1103	ААН-ын орлогын албан татвар	0.0	0.0
1104	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	0.0	0.0
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	0.0	0.0
113	Хөрөнгийн албан татвар	902,208.6	3,060,252.5
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар	0.0	0.0
115	Онцгой албан татвар	0.0	0.0
116	Тусгай зориулалтын орлого	0.0	0.0
117	Гадаад үйл ажиллагааны орлого	0.0	0.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	131,137.9	148,232.9
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	49,621.9	43,806.6
1181	Газрын төлбөр	33,286.1	50,286.4
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	48,229.8	54,139.9
1183	Бусад татвар	0.0	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	187,698.6	196,994.2
120	Нийтлэг татварын бус орлого	187,698.6	196,994.2
121	Хөрөнгийн орлого	0.0	0.0
122	Тусламжийн орлого	0.0	0.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,474,678.4	3,637,869.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,342,061.0	6,157,439.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,342,061.0	6,157,439.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	790,302.3	1,277,290.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	315,099.4	566,549.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,780.9	70,889.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	305,146.8	139,637.9
2104	Хангамж, бараа материалын зардал	30,551.4	30,701.3
2105	Нормативт зардал	456.0	155.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,945.4	42,662.6
2107	Томилолт, зочны зардал	7,078.0	23,479.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,072.1	44,971.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,172.3	358,242.3
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,551,758.7	4,880,149.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	455,911.2	1,051,140.8
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.0	0.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	374,785.0	868,574.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	374,785.0	868,574.0
2200	Дотоод эх үүсвэрээр	374,785.0	868,574.0
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0

VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-374,785.0	-868,574.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-219,484.5	-59,370.8
14	Бусад эх үүсвэр	0.0	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	219,484.5	59,370.8
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	0.0	0.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-138,358.2	123,196.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	223,370.8	85,012.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	85,012.6	208,208.6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,906,196.10	3,573,328.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,872,050.10	2,726,564.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,431,824.60	1,286,688.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	575,267.10	566,549.04
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,908.30	70,889.45
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	357,551.00	346,480.09
2104	Хангамж, бараа материалын зардал	38,262.90	27,145.45
2105	Нормативт зардал	156.00	155.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	140,000.00	108,542.56
2107	Томилолт, зочны зардал	25,580.20	22,399.74
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	87,592.50	47,471.84
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	135,506.60	97,054.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,440,225.50	1,439,875.50
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,429,789.00	1,429,789.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	1,429,789.00	1,429,789.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	0	0
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,436.50	10,086.50
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	859,034.60	787,393.99
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	175,111.40	59,370.76
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,906,196.10	3,714,648.05
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0	0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,635,784.30	3,564,189.77
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	270,411.80	150,458.28
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	36,118.10
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	177,437.31
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	56	56
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	27	27
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	27	27

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

		/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	73,679,479.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	73,679,479.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	71,781,479.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,555.88
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,080.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,145,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,898.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,898.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	73,679,479.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	73,679,479.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус байгууллага нь “Монгол улсын хуулийг дээдлэн хэрэгжүүлж, Засгийн газрын шийдвэр, аймаг сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хангасан, төсвийн болон шилэн дансны тухай хууль ОУНББ-н стандартын дагуу төсөв санхүүг оновчтой зарцуулж чанарын удирдлагын тогтолцоо ISO-9001 стандарт болон байгууллагын цахим удирдлагын цогц системийг бүрэн нэвтрүүлсэн шуурхай хариуцлагатай захирах захирагдах зарчмыг баримталсан, зөв боловсон харилцаатай, угтах үйлчилгээ нь хэвшил болсон байгууллагын соёл, багаар ажиллах чадвар төгөлдөржсөн тэргүүний хамт олон болох” зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Эдийн засаг, санхүүгийн стратегийн төлөвлөлт бодлогын шийдвэр боловсруулахад дэмжлэг үзүүлэх.
- Салбарын стратегийн төлөвлөлт, бодлогын шийдвэр боловсруулах, хэрэгжилтийг зохицуулахад дэмжлэг үзүүлэх.
- Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах.
- Иргэдэд төрийн үйлчилгээг жигд хүртээмжтэй, хөнгөн шуурхай хүргэх ажлыг зохион байгуулах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль Нийгмийн даатгалын тухай хууль Татварын тухай хууль Төрийн албаны тухай хууль Шилэн дансны хууль, Төрийн болон орон нутгийн тухай хууль Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль бусад холбогдох хууль, тогтоол, заавар, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн шууд захирагч батлагдсан төсөвт үндэслэн зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хангал сумын 2023 оны санхүүгийн тайлан дахь Тайлант онд баталсан татварын болон татварын бус орлогыг мөнгөн сууриар хөтөлж, ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/424 тоот захирамжаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хангал сумын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,036.63 сая төгрөгөөр буюу 59.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	85.01	208.21	123.20
Авлага	77.33	60.84	(16.49)
Бараа материал	223.78	350.79	127.01
Үндсэн хөрөнгө	1,116.06	1,967.27	851.21
урт хугацаат хөрөнгө оруулалт	248.61	200.32	(48.29)
Нийт хөрөнгө	1,750.80	2,787.43	1,036.63
Өр төлбөр	3.04	14.92	11.88
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,747.75	2,772.50	1,024.75
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,750.80	2,787.43	1,036.63

Эх сурвалж: Хангал сумын 2023 оны нэгтгэсэн тайлангаас

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данснууд байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 208.21 сая төгрөг болж, өмнөх оноос 123.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	85.01	208.21	123.20
Төгрөг	85.01	208.21	123.20
Төрийн сангийн харилцах	85.01	208.21	123.20
Арилжааны банк дахь харилцах	-	-	-
Гадаад валют	-	-	-
Арилжааны банк дахь харилцах	-	-	-
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-	-
Дүн	85.01	208.21	123.20

Эх сурвалж: Ханга сумын 2022 оны нэгтгэсэн тайлангаас

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 123.2 сая төгрөг нь Хангал сумын төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна.

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа ОНХО-ын дансанд 30.7 сая төгрөг, ОНХС-д 71.6 сая төгрөг, хоршоо хөгжүүлэхийн дансанд 57.4, Байгаль хамгаалах

сангийн дансанд 18.0 сая төгрөг, ЖДҮД сангийн дансанд 30.3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 60.8 сая төгрөг болж, өмнөх оноос 16.49 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	5.93	4.05	(1.87)
Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-	-
Татаас, санхүүжилтийн авлага	-	-	-
Дансны авлага /ТӨҮГ/	-	-	-
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	-	-	-
Байгууллагаас авах авлага	28.21	25.98	(2.23)
Хувь хүмүүсээс авах авлага	22.99	17.59	(5.40)
Дүн	77.33	60.84	(16.49)

Эх сурвалж: Хангал сумын 2023 оны нэгтгэсэн тайлангаас

Авлага дансны үлдэгдлийг байгууллагаар нь авч үзвэл 59.4 сая төгрөг буюу 97.6 хувийг ЖДҮДС-ийн зээл болон зээлийн хүүгийн авлага 1.2 сая төгрөг буюу 2.1 хувийг ХХС-ийн зээл болон зээлийн хүүгийн авлага, 0.12 сая төгрөг буюу 0.19 хувийг ЗДТГ, 0.01 сая төгрөг буюу 0.02 хувийг ИТХ-ын авлагын үлдэгдэл тус тус эзэлж байна.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 0.0 сая төгрөг байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	0	0	0
Урьдчилгаа тооцоо	0	0	0
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	0	0	0
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	0	0	0
Дүн	0	0	0

Эх сурвалж: Хангал сумын 2023 оны нэгтгэсэн тайлангаас

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 200.7 сая төгрөг болж, өмнөх оноос 22.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	0	0	0
Тусгай зориулалттай материал	0	0	0
Эм боох материал	0	0	0
Дуусаагүй үйлдвэрлэл	0	0	0
Бэлэн бүтээгдэхүүн	6.50004	6.71284	0.2128
Хангамжийн материал	33.57101	32.53697	-1.03404

Бичиг хэргийн материал	14.05886	7.865	-6.19386
Аж ахуйн материал	0.369301	0.620289	0.250988
Сэлбэг хэрэгсэл	0	0	0
Түлш, шатах тослох материал	0	0	0
Барилгын засварын материал	159.5501	142.595	-16.955
Хүнсний материал	0	0	0
Бусад хангамжийн материал	9.732	10.46	0.728
Мал амьтад	0	0	0
Дүн	223.7813	200.7901	-22.9912

Эх сурвалж: Хангал сумын 2023 оны нэгтгэсэн тайлангаас

Бараа материалын үлдэгдлийг байгууллагаар нь авч үзвэл Байгаль хамгаалах сан 12.6, ЗДТГ 182.5, ИТХ 5.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант онд ЗДТГ 11.8, байгаль хамгаалах сан 12.8 сая төгрөгөөр бараа материал буурсан бол, ИТХ 1.7 сая төгрөгөөр өссөн байна.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 0.0 сая төгрөг болж, өмнөх оноос 0.0 сая төгрөг буюу өөрчлөлт гараагүй байна.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	0	0	0
Дүн	0	0	0

Эх сурвалж: Хангал сумын 2023 оны нэгтгэсэн тайлангаас

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 1,967.3 сая төгрөг болж, өмнөх оноос 851.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	673.73	647.03	(26.70)
Авто-тээврийн хэрэгсэл	32.00	40.05	8.05
Машин тоног төхөөрөмж(компьютер)	196.95	200.29	3.34
Тавилга, аж ахуйн эд хогшил	31.71	51.78	20.07
Түүх соёлын дурсгалт зүйл	90.00	90.00	-
Дуусаагүй барилга байгууламж	-	-	-
Номын фонд	0.50	0.50	-
Бусад үндсэн хөрөнгө	85.62	92.09	6.47
Програм хангамж	5.45	7.40	1.95
Бусад биет бус хөрөнгө	0.10	838.13	838.03
Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/ + Бусад	-	-	-
Дүн	1,116.06	1,967.27	851.21

Эх сурвалж: Хангал сумын 2023 оны нэгтгэсэн тайлангаас

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдлийг байгууллагаар нь авч үзвэл 1,922.7 сая төгрөг буюу 97.6 хувийг ЗДТГ, 44.5 сая төгрөг буюу 2.3 хувийг ИТХ-ын авлагын үлдэгдэл тус тус эзэлж байна.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 14.9 сая төгрөг болж, өмнөх оноос 11.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	/ сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Богино хугацаат үнэт цаас	-	-	-
Богино хугацаат зээлийн өглөг	-	-	-
Өглөг	3.04	14.92	11.88
Ажилчидтай холбогдсон өглөг	-	-	-
Бараа үйлчилгээний зардлын өглөг	1.12	-	(1.12)
Бусад өглөг	1.92	14.92	13.00
Байгууллагад төлөх өглөг	1.92	14.92	13.00
Хувь хүмүүст төлөх өглөг	-	-	-
Урьдчилж орсон орлого	-	-	-
Дүн	3.04	14.92	11.88

Эх сурвалж: Хангал сумын 2023 оны нэгтгэсэн тайлангаас

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 100 хувь буюу 14.9 сая төгрөг орон нутгийн хөгжлийн сангийн хөгжүүлэх сангийн байгууллагад төлөх өглөг байна.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,772.5 сая төгрөг болж, өмнөх оноос 1,024.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/ сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	249.45	249.45	-
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	-	-	-
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	-	-	-
Хуримтлагдсан үр дүн	1,470.52	2,495.27	1,024.75
Өмнөх үеийн үр дүн	3,155.24	1,470.50	(1,684.74)
Тайлант үеийн үр дүн	(1,684.73)	1,024.76	2,709.49
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	27.79	27.79	-
Дүн	1,747.75	2,772.50	1,024.75

Эх сурвалж: Хангал сумын 2023 оны нэгтгэсэн тайлангаас

Засгийн газрын хувь оролцоо өмнөх оны үлдэгдлээс 58.6 хувиар өссөн нь тайлант оны үйл ажиллагааны нийт үр дүн 1,024.7 буюу зэрэг үзүүлэлтэй гарсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 19-ны XI/06 тоот тогтоолоор сумын 2023

оны төсвийг 2,307.9 сая төгрөгөөр баталж сумын татварын болон татварын бус орлогыг 1,967.6, төсөвт байгууллагын өөрийн орлого 3.4 сая, ОНХС-гаас олгох шилжүүлэг 161.5, төгрөг, урьд оны үлдэгдлээс 27.8, 2022 оны малын тоо толгойн татварын орлого 34.0 сая төгрөгөөр үйл ажиллагаа болон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлын эх үүсвэрийг тус тус баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Сумын ИТХ-2023 оны 08 дугаар сарын 25-ны ХҮ/01 тоот тогтоолоор сумын 2023 оны төсвийг тодотгон төсвийг 3,906.1 сая төгрөгөөр баталж сумын татварын болон татварын бус орлогыг 3,509.3 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлого 0.4 сая төгрөгөөр, ОНХС-гаас олгох шилжүүлэг 859.0 сая төгрөгөөр, урьд оны үлдэгдлээс 85.0 сая төгрөгөөр, 2022 оны малын тоо толгойн татварын орлого 38.7 сая төгрөгөөр баталжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 3,696.5 сая төгрөг, ОНХС-гаас 125.8 сая төгрөг, үйл ажиллагаанаас 366,0 төгрөг, СХС-аас 98.3 сая төгрөгийн зээл төлөгдөж, орлого 124.6 сая төгрөгөөр дутуу биелсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,573.3 буюу 96.6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 123.6 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	179.79	153.06	26.73	85.1
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	916.04	874.76	41.28	95.5
3	Орон нутгийн зорилтот Хөрөнгө оруулалт	859.03	787.39	71.64	91.7
4	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	40.64	39.73	0.91	97.8
5	Соёл урлаг	29.00	2.90	26.10	10.0
6	Сургуулийн өмнөх боловсрол	30.01	23.04	6.96	76.8
7	Ерөнхий боловсрол	173.90	170.77	3.13	98.2
Нийт		2,228.42	2,051.66	176.76	92.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын илрүүлэлт:

- Шатахууны зардлыг илүү тооцон 0.4 сая төгрөгийг олгосон зөрчилд төлбөрийн акт хүргүүлсэн./ЗДТГ/
- Албан бус ажил буюу золголтоор явахад томилолтын зардалд 0.4 сая төгрөгийг зарцуулсан зөрчилд төлбөрийн акт хүргүүлсэн./ЗДТГ/
- Засаг даргын нөөц хөрөнгөөс нийт 2.02 сая төгрөгийг холбогдох журмыг баримтлаагүй зориулалт бус зарцуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн./ЗДТГ/
- ИТХ-ын дарга хууль, тогтоомж, журмын үндэслэлгүйгээр 1.0 сая төгрөгийн урамшуулал авсан зөрчилд төлбөрийн акт хүргүүлсэн./ИТХ/
- Албан бус ажлаар явсан ажилтанд томилолтын зардлыг 0.09 сая төгрөгөөр, томилолтоор ажилласан ажилтанд хоолны 0.07 сая төгрөгийг илүү тооцож олгосон зөрчилд төлбөрийн акт хүргүүлсэн./ИТХ/
- ОНХС-гийн хөрөнгөөр хууль, журамд нийцээгүй 3 төсөл арга хэмжээг ИТХ -аар батлуулж нийт 46.5 сая төгрөгийг зарцуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн./ОНХС/

- ХХС-аас зээд авсан иргэд Хоршоо хөгжүүлэх сангийн журмын 7.10-д заасны дагуу төслийг зориулалтын дагуу хэрэгжүүлж, төслийн талаарх тайлангаа сумын иргэд, олон нийтэд тайлагнаагүй зөрчилд зөвлөмж хүргүүлсэн./ХХС/

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 73.6 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч эдийн засгийн ангиллын дагуу зарцуулалтын эрх нээлгэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хангал сумын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Намчинсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Хангал сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 01/34 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны үр дүнгийн тайлангийн өмнөх оны нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны үр дүнгийн тайлангийн 2,804.0 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 36,502.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийн дагуу ажиллажээ

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна. Мөн хуулийн 15 дугаар зүйлд заасан хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Төсвийн шууд захирагчдын хүрээнд Төрийн хэмнэлтийн хуулийн 14.1, 15.1.5-ийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ.Үүнд:

Аудитын илрүүлэлт:

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин бэлэг дурсгалын зүйл, хүнсний зардалд нийт 0.6 сая төгрөгийг зарцуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоосон. /ЗДТГ/
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин нийт 11.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг цахим дэлгүүрээс худалдан аваагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн./ЗДТГ/
- Нийт 4.4 сая төгрөгийн хөрөнгийг цахим дэлгүүрээс худалдан аваагүй, мөн тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн. /ИТХ/

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хангал сумын ТТЗ нь шилэн дансны хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Төсвийн шууд захирагчдын хүрээнд Шилэн дансны тухай хуулийн 6.4.5,6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

- Шилэн дансны цахим хуудсанд нийт 29 удаагийн 9.6 сая төгрөгийн хөрөнгө зарцуулах шийдвэр, 22 удаагийн нийт 662.7 сая төгрөгийн таван сая төгрөгөөс дээш орлогын гүйлгээг мэдээлээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн./ЗДТГ/
- Таван сая төгрөгөөс дээш 1 удаагийн 66.1 сая төгрөгийн зарлагын гүйлгээ, 11 удаагийн 191.9 сая төгрөгийн орлогын гүйлгээ, 1 удаагийн 200.3 сая төгрөгийн хөрөнгө зарцуулах захирамжийг мэдээлээгүй, 7 удаагийн 522.7 сая төгрөгийн хөрөнгө зарцуулах захирамжийг хугацаа хоцроон тус тус мэдээлсэн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн./ОНХС/
- Төсөв зарцуулахтай холбоотой нийт 8 удаагийн нийт 41.3 сая төгрөгийн захирамжийг хугацаа хоцроон мэдээлсэн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн. /ХХС/
- Шилэн дансны цахим хуудсанд 11 удаагийн 118.5 сая төгрөгийн 5 сая төгрөгөөс дээш орлогын гүйлгээ, 2 удаагийн 2,000.0 мянган төгрөгийн төсөв хөрөнгө зарцуулах шийдвэрийг мэдээлээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй болно.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. Зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр 01/836 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	4	15.9	4	15.9	100
Нийт дүн	4	15.9	4	15.9	100

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтэд анхаарах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

ТТЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилд¹ 3.4 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 1 зөвлөмж өгч ажиллаа.

Төсвийн шууд захирагчийн хүрээнд аудитаар нийт 2,788.3 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 2.65 сая төгрөгийн 5 төлбөрийн акт тогтоож, 1,905.66 сая төгрөгийн 9 албан шаардлага хүргүүлж, 41.3 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлангийн үзэл баримтлал

Илрүүлэлт:

Төсвийн тухай хуулийн 54.4.5 дахь заалтын дагуу тайлангийн иж бүрдлийг хангаж ирүүлээгүй нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Жилийн эцсийн ТТЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.4.5, дахь заалт, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт дагуу тайлангийн иж бүрдлийг хангаж ирүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая.төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	1	837.1	1	837.1			1	837.1				
ИТХ	1	0.98	1	0.98			1	0.98				
Дүн	2	838.08	2	838.08			2	838.08				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая.төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТТЗ	2	3.4	1	3.4			1					
ЗДТГ	4	3.5	3	1.4	1	2						
ИТХ	2	1.23	2	1.23								
ХХС	1						1					
Дүн	9	8.13	6	6.03	1	2	2					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая.төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ЗДТГ	1	672.4			1	672.4		-
ОНХС	1	1048.0			1	1048		-
ХХС	1	41.3					1	41.3
ИТХ	1	120.5			1	120.5		
Дүн								-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ЗДТГ	3	12.4	1	0.63	1	11.8		-
ОНХС	1	46.5			1	46.5		-
ИТХ	1	4.44			1	4.44		
Нийт дүн								-